

## ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ /2023.11.25-2023.12.25/

2023 оны 11-р сарын 29-ний өдөр Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит 25-р хуралдаан хуралдав. Тус хуралдаанаар:

- ✚ Мал амьтныг халдварт паразиттих өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө
- ✚ Орон нутгийн орлогын бүрүүлэлт, зарцуулалт
- ✚ Хоршоо хөгжүүлэх сан, ОНХС
- ✚ Сумын хамтарсан баг
- ✚ Иргэдийг малжуулах журам
- ✚ Сумын нутаг дэвсгэрт нохой муур тэжээх, арчлах, золбин нохой устгахад мөрдөх журам
- ✚ Газар зохион байгуулалтын 2023 оны тухайн жилийн төлөвлөгөө зэрэг асуудлуудыг хэлэлцүүлэв.



### **“ХҮН АМ, МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТООЛЛОГО”**

Сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/164 тоот захирамжаар 25 гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилогдож, сумын хэмжээнд 2023 оны жилийн эцсийн "Хүн ам, мал, тэжээвэр амьтдын тооллого" 2023 оны 12 дугаар сарын 7-ноос 12 дугаар сарын 17-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Урьдчилсан тоогоор сумын 1 дүгээр багт 632 өрх, 2343 иргэн, 2 дугаар багт 328 өрх, 1022 иргэн тоологдоод байна. Тооллогын мэдээллийг ХАӨМС болон бусад программуудад шивэлт хийгдэж байна.



2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Аймгийн Статистикийн хэлтэстэй хамтран “Статистик мэдээллийг хаанаас авах вэ?” нээлттэй хаалганы өдөрлөгийг сумын хэмжээнд зохион байгуулж, 20 гаруй иргэнд статистик тоон мэдээллийг гарган өгч, үйлчлээд байна.



### **Сумын Онцгой бэлэн байдлын шүүрхай штабыг томиллоо.**

Сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/171 тоот захирамжаар 38 гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилогдож, сумын хэмжээнд “Онцгой байдлын штаб”-ыг томилгоожуулан, хуваарийн дагуу бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

№	Ажлын хэсэгчдийн нэр	Байгууллага	Адрес	Ажиллах хугацаа	Утас
1	П.Ганзориг	ЗДТГ	ХААТ-ын мэргэжилтэн		95160919
2	С.Очираа	ЗДТГ	2-р Бэлэн Засаг дарга	2023.12.19 08:30-18:00	95780132
3	С.Очираа	З-р Сургууль	Төлөөлөгчдийн мэргэжилтэн		99441231
4	М.Мөнхбаяр	ЗДТГ	ЗДТГ-ын ХААТ-ын мэргэжилтэн		99786223
5	Б.Түвшинсүх	ЗДТГ	ЗДТГ-ын Төсв, Төрийн сангийн мэргэжилтэн	2023.12.20 08:30-18:00	99041172
6	Х.Түвшинсүх	З-р Сургууль	МЭТ Тарвагч гүйц		95691399
7	Г.Давдсэлэг	ЗДТГ	Урьд	2023.12.21 08:30-18:00	95690111
8	С.Очираа	З-р Сургууль	Болов		95110990
9	П.Ганзориг	ЗДТГ	ХААТ-ын мэргэжилтэн		95160919
10	П.Ганзориг	Мөнх-Шивээ ОНБУААГ	Мастер	2023.12.22 08:30-18:00	99912307
11	Б.Мөнхзориг	ОНБУААГ	МЭСТ-ТХААТ-ын мэргэжилтэн		99490020
12	А.Амарсүх	ЗДТГ	ЗДТГ-ын ХААТ-ын мэргэжилтэн		99786223
13	Д.Мөнхбаяр	ЗДТГ	ЗДТГ-ын ХААТ-ын мэргэжилтэн	2023.12.23 08:30-18:00	99786223
14	Г.Бидеэл	Солонсог	Дарга		99002045
15	О.Сэлэнгэ	3-р Сургууль	МЭТ Тарвагч гүйц		95090600
16	Г.Давдсэлэг	Мөнх-Шивээ ОНБУААГ	Арван, Бөхөг хурал, ХТ-ийн дарга	2023.12.24 08:30-18:00	99311622
17	Б.Түвшинсүх	ОНБУААГ	ИТХ-ын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын		94933330
18	О.Очираа	ЗДТГ	ХААТ-ын мэргэжилтэн		95160919
19	П.Ганзориг	ЗДТГ	ХААТ-ын мэргэжилтэн		95160919
20	С.Очираа	Мөнх-Шивээ ОНБУААГ	Орлогын менежер	2023.12.25 08:30-18:00	99001540
21	Б.Түвшинсүх	3-р Сургууль	Болов		95090122
22	Д.Мөнхбаяр	ЗДТГ	ЗДТГ-ын ХААТ-ын мэргэжилтэн		99786223
23	П.Бадрах	ЗДТГ	1-р Бэлэн Засаг дарга	2023.12.26 08:30-18:00	99929700
24	Д.Отгончимэг	Мөнх-Шивээ ОНБУААГ	Орлогын байцаач		

2023 оны 12 дугаар сарын 19-ний өдөр Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит бус 26-р хуралдаан хуралдав. Тус хуралдаанаар:

- ✚ Газар зохион байгуулалтын 2024 оны тухайн жилийн төлөвлөгөөний санал
- ✚ Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилт
- ✚ 2024 оны төсвийн төсөл
- ✚ Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны бүтэц орон тоо зэрэг асуудлуудыг хэлэлцүүлэв.



### **НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан Улсын Их Хурлын даргын ивээл дор жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Шатар сохирхогчдын сумын аварга шалгаруулах анхан шатны тэмцээнийг 2023 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр сумын ИТХ-ын ажлын алба, "Оюунлаг спорт" шатар сонирхогчдын клубтэй хамтран зохион байгуулсан. Тус тэмцээн нь эрэгтэй, эмэгтэй гэх 2 ангиллаар зохион байгуулагдсан бөгөөд эрэгтэй ангилалд 8 тамирчин, эмэгтэй ангилалд 5 тамирчин оролцсон.



2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Олон Улсын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан сумын Засаг даргын Тамгын газар, сумын "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөл"-тэй хамтран, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд "БИ ЧАДНА" хөгжөөнт тэмцээн, арга хэмжээг зохион байгууллаа.



Шивээговь сумын ИТХ-ын ажлын албанаас "Төлөөлөгчдийн нэг өдөр" өдөрлөгийн хүрээнд "Дуулах өдөр" караоке дууны тэмцээнийг 2023 оны 12 дугаар сарын 09-ний өдөр зохион байгууллаа. Тус арга хэмжээ нь иргэдийн дуулах ур чадварыг нээн илрүүлж, цаашид урлаг соёлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, авъяас билгээ өвлүүлэн уламжлуулж, хадгалан хамгаалах зорилготой болно.



2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан “2023 ОНЫ ОНЫ ОНЦЛОХ ХҮҮХЭД, ОНЫ ОНЦЛОХ БАГШ” шалгаруулах ёслолын ажиллагаагаар сумын хүүхдийн зөвлөл нь “2023 ОНЫ ОНЦЛОХ СУМЫН ХҮҮХДИЙН ЗӨВЛӨЛ”-өөр шалгарав.



### ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

2023 оны 12-р сарын 25-ны байдлаар “Шивээговь сум мэдээ” цахим хуудсанд нийт 38 мэдээ мэдээлэл байршуулснаас 16 мэдээг байгууллагаас бэлтгэн байршуулж, 22 мэдээг бусад байгууллагаас шэйрлэж мэдээллэсэн байна.

Нэг цэгийн үйлчилгээг операторын горимд шилжүүлснээр иргэд дараах үйлчилгээнүүдийг e-mongolia цахим системээс цаг алдалгүй авах боломжтой. 12 дугаар сарын байдлаар нийт 32 лавлагааг иргэдэд үзүүлсэн байна. Үүнд:

- Иргэний үнэмлэхийн лавлагаа-13
- Оршин суугаа хаягийн лавлагаа -1
- Нийгмийн даатгал шимтгэл төлөлтийн талаарх лавлагаа-7
- Жолоочийн мэдээллийн лавлагаа-1
- Зээлийн мэдээллийн лавлагаа-4
- Эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөлт авсан тусламж үйлчилгээний мэдээлэл-2
- Өндөр настны тэтгэвэр тогтоолтын хуудас-1
- Эрүүл мэндийн даатгалын төлөлт шалгах-1
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт-1
- Мэргэшсэн жолоочийн үнэмлэхийн лавлагаа-1



“Шивээговь сум мэдээ” цахим хуудсаар иргэдэд цаг үеийн нөхцөл байдал, аймгийн болон улсын Онцгой байдлын газраас анхааруулж буй сэрэмжлүүлэг, цаг агаарын аюултай үзэгдэлээс сэргийлэх сэрэмжлүүлэх мэдээг иргэдэд тогтмол мэдээллэж, хүргэн ажиллаж байна.

**Нуур, голуудын мөсний даах чадвар**

7 см-ээс бага зууван мөсөн дээгүүр хэв гажих хүн явахад цөмрөх аюултай.	Мөсөн дээрээс 1 хүн заагагчлах боломжтой.	Цасны машин болон мотоцикль явахад даана.	Жижиг суудлын тэрэг явахад даана.	Жил болон пикап машин явахад даана.	10-20 тн давцтай машин явахад даана.	30-40 тн давцтай машин явахад даана.
< 7 см	10 см	12 см	20-30 см	30-38 см	40-60 см	70-95 см

www.nema.gov.mn

**ОСГОЖ, ХӨЛДСӨН ЦЕД ДАРААХ ЗҮЙЛСИЙГ ХОРИГЛОНО:**

- Ил гал, зууханд зэхгүй
- Хөлдөж, осгосон хөлөөрөө алхахгүй
- Осгосон хэсгийг црэх, массаж хийхгүй
- Дулаацуулахын тулд архи согтууруулах ундаа хэрэглэхгүй

www.nema.gov.mn

**ОНХС-ийн талаар**

“Хүүхэд залуучуудыг дэмжих арга хэмжээ”-ний хүрээнд фитнес тоног төхөөрөмж худалдан авах ажлын техникийн тодорхойлолтыг боловсруулж шууд худалдан авалтын ажлыг зарлаж 2023 оны 12 сарын 01-ний өдөр шалгаруулсан бөгөөд тус ажилд 1 гүйцэтгэгч компани орж ирсэн боловч баримт бичгийн шаардлага хангахгүй байсан тул цуцалж, дахин зарлахаар ажиллаж байна.

“Боловсролын байгууллагад ширээ, сандал, компьютер нийлүүлэх тухай” 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр зарлагдсан тендерийн гүйцэтгэгч компани шалгарч, 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр тус компанитай гэрээг хийж, 12 дугаар сарын 08-ны өдөр ажил хүлээлцэх ажлын хэсэг тоног төхөөрөмжийн тоо хэмжээний дагуу 60ш ширээ, 120ш сандал, 6 нөүтбүк болох бараа материалыг хүлээж аваад байна.



2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр сумын аюулгүйн нөөцөд шууд худалдан авалтаар малын тэжээл /хивэг/ худалдан авах ажлын даалгаврыг цахим хуудаст байршуулаад байна. Мөн 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ээлжит бус 26 дугаар хуралдаанаар ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө батлагдсан.

**ШИВЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

✓ 2023 ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ САНГИЙН ХӨРӨНГӨӨР СУМЫН АЮУЛГҮЙН НӨӨЦӨД ШУУД ХУДАЛДАН АВАЛТААР МАЛЫН ТЭЖЭЭЛ “ХИВЭГ” ХУДАЛДАН АВАХ АЖЛЫН ДААЛГАВАР :

✓ **ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГА:**

- УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУУЛБАР
- БАРААГ ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГАД ХҮЛЭЭЛГЭЖ ӨГӨХ.
- ТАТВАРЫН ТОДОРХОЙЛОЛТ
- ХАРИЛЦАХ БАНКНЫ ТОДОРХОЙЛОЛТ

✓ **ТЕХНИКИЙН ШААРДЛАГА:**

- ҮЙЛДВЭРИЙН ТЭЖЭЭЛ БАЙХ
- 25 КГ САВЛАГДСАН БАЙХ
- ҮЙЛДВЭРИЙН ДАГАЛДАХ БИЧИГТЭЙ БАЙХ
- ТЭЖЭЭЛ ХУУРАЙ БАЙХ
- САВ БАГЛАА БООДОЛ БАТ БӨХ
- ТОО ШИРХЭГ 100

✓ **ЭНЭХҮҮ ШААРДАГИЙГ ХАНГАСАН АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛАГА 2023 ОНЫ 12-Р САРЫН 20-НЫ 14:00 ЦАГТ ХОЛБОГДОХ БИЧИГ БАРИМТАА БҮРДҮҮЛЖ ЗДТГ-ЫН 202 ТООТ ӨРӨӨНД АВЧИРЧ УУЛЗНА УУ. МӨН БҮРДҮҮЛСЭН БИЧИГ БАРИМТАА ДООРХ ХАЯГААР ИРҮҮЛЖ БОЛНО.**

shiveegowi2020shtab@gmail.com

99786323

**Үнийн санал: 3000000 / гурван сая төгрөг/**

## Төсөв, төрийн сангийн талаар

Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацааны дагуу оруулж байна.

Мөн сар бүр:

- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)
- Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт

Тухай бүр:

- Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ зэрэг мэдээ тайланг тайлагнаж байна.

Орон нутгийн 15 нэр төрлийн татварын орлого бүрдүүлэхээс 12 дугаар сарын байдлаар 11 төрлийн татварын орлого бүрдээд байна. ОН-ын татварын орлого гүйцэтгэлээр 1,797,981,800 төгрөг бүрдсэн байна.

Шивээговь сумын орон нутгийн татварын орлого						
Татварын төрлийн нэр	Төрийн сангийн данс	Жилийн батлагдсан төлөвлөгөө	Өссөн дүнгээр			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
Газрын төлбөр	100220300943	171,680,000	128,700,000	24,521,538.40	104,178,461.60	19.05
Галт зэвсгийн албан татвар	100220300922	1,070,000	900,000	450,000.00	450,000.00	50.00
Иргэний үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогоос суутгасан албан татвар	100220300962	5,000,000	4,150,000	18,189,353.12	(14,039,353.12)	438.30
Малын тоо толгойн албан татвар	100220300917	45,000,000	35,000,000	6,958,200.00	28,041,800.00	19.88
Хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татвар	100220300975	20,000,000	16,600,000	18,406,499.83	(1,806,499.83)	110.88
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	100220300948	3,000,000	2,500,000	24,237,500.00	(21,737,500.00)	969.50
Улсын тэмдэгтийн хураамж	100220300941	3,000,000	2,500,000	3,249,972.11	(749,972.11)	130.00
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	100220300947	18,000,000	15,000,000	4,707,500.00	10,292,500.00	31.38
Хувь хүний орлогын албан татвар	100220300911	10,000,000	8,300,000	3,351,441.53	4,948,558.47	40.38
Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар	100220300901	1,686,192,500	1,410,199,100	1,213,075,985.84	197,123,114.16	86.02
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	100220300921	297,000,000	222,750,000	168,247,677.15	54,502,322.85	75.53
Суутгагчийн ХХ-д олгосон ОАТ / шууд бус орлого/	100220300912	(48,617,300)	(48,617,300)	6,771,790.00		
Иргэний эрх борлуулсны орлого АТ	100220300916			124,920.00		
Иргэний ҮХЭХАТ	100220300924			35,328,341.97		
Газрын үл хөдлөх эд хөрөнгийн АТ	100220300923			73,835.00		
<b>Нийт дүн</b>		<b>2,211,325,200</b>	<b>1,797,981,800</b>	<b>1,527,694,554.95</b>	<b>361,203,432</b>	<b>84.97</b>

### Хүрээлэн буй орчны чиглэлээр

Сумын хэмжээнд золбин нохой муур устгалын ажлыг 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулан ажилласан. Устгалаар 1-15-р байр, зүүн гэр байр, урд гэр байр, 21-р зөрлөг, Страто ХХК, 22-р зөрлөг, Шивээ-Овоо ХК маршрутаар нохой устгалыг хийж 59 нохойг устгаж 2 кг ариутгалын бодисоор халдваргүйжүүлэлт хийж булж устгаад байна.



“Хоггүй сум” арга хэмжээний хүрээнд сумын хог хаягдлыг 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дараах хуваарийн дагуу ачиж, тээвэрлэж байгаа бөгөөд хүйтний улирал эхэлсэнтэй холбоотойгоор хог хаягдлын ачилтыг өвлийн цагийн хуваарьт оруулаад байна. Мөн ахуйн хог хаягдлаа орц подвал, байрны гаднах хогны саванд хаялгүй хуваарийн дагуу ачиж байхыг иргэд, олон нийтэд тогтмол сануулж ажиллаж байна.

ШИВЭЭГОВЬ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**СУМЫН ААН, АЛБАН БАЙГУУЛЛАГА, АЙЛ ӨРХ, ГЭР  
ХОРООЛЛЫН АХУЙН ХОГ АЧИХ ХУВААРЬ**

№	ГАРАГ	ХУГАЦАА	ХУВААРЬТ ГАЗРУУД
1	Даваа Бямба	10:00-17:00	Гэр хороолол
2	Мягмар	10:00-12:30	2,3,5,6,7,8 байр
		13:30-14:30	9,10 байр
		14:30-15:30	12,13 байр
		15:30-16:30	14,15 байр
3	Пүрэв	10:00-12:30	2,3,5,6,7,8 байр, албан байгууллага аж ахуй нэгж
		13:30-14:30	9,10 байр
		14:30-15:30	12,13 байр
		15:30-16:30	14,15 байр
4	Ням	10:00-12:30	2,3,5,6,7,8 байр
		13:30-14:30	9,10 байр
		14:30-15:30	12,13 байр
		15:30-16:30	14,15 байр

### Эрүүл мэндийн чиглэлээр

Сумын Эрүүл мэндийн төв томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол авч ажиллаж байгаа бөгөөд үүнд:

- ✚ Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын хүн амыг вакцинжуулалтад хамруулсан ба хамруулах шаардлагатай 492 иргэн бүрэн хамрагдаж, хамрагалт 100%-тай хэрэгжсэн.
- ✚ Мөн 12 дугаар сарын 01-ний өдөр сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдийн дархлаажуулалтыг дэмжиж, 113 хүүхдэд норм, нормативын дагуу Витамин А-г уулгаж, үлдсэн 100 гаруй хүүхдүүдэд Витамин А-г эцэг эх, асран хамгаалагчид уулгах зохистой хэмжээний хамт тарааж өгсөн.
- ✚ 2023 оны 11 сарын сүүлчээр сумын хэмжээнд томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлж, тархалтыг хянах, багасгах зорилгоор “Маскаа зүүцгээе” аяныг өрнүүлээд байна.



## УРИАЛГА

Хүүхэд бүр гар ариутгагч хэрэглэж хэвшье. Ханиаднаас сэргийлэхийн тулд тогтмол гараа угаацгаая.



ГАРАА УГААЦГААЯ  
ГАРАА АРИУТГАЯ.



Хүүхэд бүр маскаа зүүж хэвшицгээе. Ханиаднаас сэргийлэхийн тулд тогтмол амны хаалтаа зүүцгээе.



МАСКАА ЗҮҮЦГЭЭЕ.



Сумын Эрүүл мэндийн төв томуу, томуу төст өвчний тархалт ихсэж дэгдэлтийн түвшинд байгаа тул хэвтүүлэн эмчлэх, үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор амбулаторын тусламж үйлчилгээ үзүүлэх цагийг 2023 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн уртасгаж ажиллаж байна.

### Боловсролын хүрээнд

Говьсүмбэр аймгийн хэмжээний “БАГА ОЛИМП” хүүхдийн спортын наадмын сагсан бөмбөгийн тэмцээн 2023 оны 11 дүгээр сарын 18-19, 11 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ба 9-12 дугаар ангийн нийт 28 баг, 224 хүүхэд оролцож, сумын Ерөнхий боловсролын сургуулийн эмэгтэй баг тамирчид хүрэл медалийн байранд шалгараад байна.



МЭДЭЭГ БЭЛТГЭСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН  
МЭРГЭЖИЛТЭН

М.ГАНТУЯА

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГА

Ч.СУГАРМАА